



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 он)



АГУУЛГА

1.	Нийтлэг үндэслэл	2-7
2.	Мандатын шинжилгээ	7-12
3.	Алсын хараа	12
4.	Эрхэм зорилго	12
5.	Орчны шинжилгээ	12-19
6.	Стратегийн зорилго	19
7.	Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	20-70
8.	Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал Хавсралт	71-75
9.	- Орон нутгийн төсвийн төсөөлөл - Хуулийн лавлагаа	76-120

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна”, 53.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу “Говьсүмбэр аймгийн стратеги төлөвлөгөө”-г боловсрууллаа.

Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах заавар” зэрэг эрх зүйн баримт бичигт үндэслэн 2013-2016 онд “Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаал нь Сангийн сайдын 2017 оны 13 дугаар тушаалаар хүчингүй болсон тул 2017 оноос хойш аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулаагүй байна.

Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангах, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чиг үүргийн хүрээнд хуулиудыг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг ханган ажиллах нөхцөл бий болоод байна.

Үүнээс гадна Монгол улсын болон орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

үүднээс аймгийн стратеги төлөвлөгөөг эрх зүйн баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэхэд орон нутаг дахь засаг захиргааны нэгж, нутгийн захиргаа, төрийн үйлчилгээ, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг чиглүүлэх, уялдуулан зохицуулах баримт бичиг юм.

Аймгийн өнөөгийн байдал:

Говьсүмбэр аймгийг Улсын Их хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Аймаг, сум байгуулах тухай” 32 дугаар тогтоолоор Чойр хотын хилийн цэсээр Сүмбэр, Баянтал, Шивээговь гэсэн 3 сумтай байгуулсан. Засаг захиргааны 3 сум, 10 багтайгаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Говьсүмбэр аймаг нь 554.1 мянган га газар нутагтай, үүнээс хөдөө аж ахуйн эдэлбэр газар 480.9 га, хот суурин газар 66.6 га, зам, шугам сүлжээ 54.4 га, усан сан бүхий газар 15.3 га, улсын тусгай хэрэгцээний газар 59.6 мян. га газрыг тус тус эзэлдэг.

2020 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймаг 18008 хүнтэй болж, үүнээс эрэгтэй 9068, эмэгтэй 8940 байна. Өмнөх онтой харьцуулбал хүн ам 563 буюу 3.2 хувиар, үүнээс эрэгтэй 272 буюу 3.1 хувиар, эмэгтэй 291 буюу 3.4 хувиар тус тус өссөн. Нийт хүн амын 50.4 хувийг эрэгтэйчүүд, 49.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн 6262 буюу 34.8 хувийг 0- 14 насны хүүхэд, 10533 буюу 58.5 хувийг 15-59 насны хүмүүс, 1213 буюу 6.7 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 405, 80 ба түүнээс дээш настан 135, 90 ба түүнээс дээш настан 16 бүртгэгдсэн байна.

Хүн амыг суурьшлаар нь авч үзвэл Сүмбэр суманд 13086, Шивээговь суманд 3821, Баянтал суманд 1105 иргэн оршин сууж байна. Аймгийн хэмжээнд 5066 өрхтэй. Үүнээс Сүмбэр сум 3683, Баянтал сум 340, Шивээговь сум 1043 өрхтэй байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 450.9 мянган толгой мал тоологдсоноос адуу 22.7, үхэр 16.3, тэмээ 1.1, хонь 218.4, ямаа 192.4 мян. толгой байна.

2019 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн 112903.2 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 26.6 хувиар өсөж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 6463.8 мянган төгрөгт хүрсэн.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оноос 37.2 хувиар өсөж, 2020 оны жилийн эцсийн байдлаар 66649.1 сая төгрөгт хүрсэн бөгөөд 60710.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 96.1 хувийг Шивээ-Овоо ХК дангаараа үйлдвэрлэж байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 377 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж, 6774 иргэнийг ажлын байраар хангаж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг ангилж үзвэл төсвийн байгууллага 60, төрийн бус байгууллага 49, компани 235, хоршоо 11, нөхөрлөл 14, Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 6, бусад 2 байгууллага байна. Нийт ажил эрхэлж байгаа иргэдийн 50.1 хувь нь эрэгтэй, 49.9 хувь нь эмэгтэй.

Өмнөх 4 жилд аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлого “Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 5 бодлого, зорилтыг хэрэгжүүлэх 119 арга хэмжээ нь 4 жилийн дундаж үнэлгээгээр 90 хувьтай хэрэгжсэн байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийг ая тухтай, аюулгүй орчинд амьдарч, сурч боловсрох нөхцөлийг хангах зорилтыг тавьж, хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах чиглэлээр 16 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан.

Говьсүмбэр аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарч буй ололт амжилт, ахиц өөрчлөлтийн үр дүнд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын үнэлгээгээр Говьсүмбэр аймаг улсын хэмжээнд 2018 онд 9 дүгээр, 2019 онд 8 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр гаргадаг аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээг ахиулсан аймгуудын нэг болж, 2019 онд 6 дугаарт, 2020 онд 5 дугаарт эрэмбэлэгдсэн бөгөөд дэд бүтцийн хөгжлөөр 3 дугаар, засаглалын үр ашгийн үзүүлэлтээр 4 дүгээр, бизнесийн үр ашгийн

үзүүлэлтээр 2 дугаар байранд байгаа нь манай аймгийн хувьд үндсэн дэд бүтэц, боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээрээ улсын хэмжээнд тэргүүлэх аймгуудын тоонд багтаж байгааг харуулж байна.

Мөн “Хүний хөгжлийн индекс” 2000 онд 0.671 байсан бол 2019 онд 0.717 болж өссөн бөгөөд нийслэл хот, 21 аймгаас 5 дугаар байранд эрэмбэлэгдэж байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт.1 Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрсэн түвшин			
		2016	2017	2018	2019	2020
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ						
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн /сая.төг/	81466	83959.4	89146	112903.18	112903.18
2	Төсвийн орлого бүрдүүлэлт /сая.т/	5 550.4	4 400.0	5 781.5	6 469.6	5520.4
3	Төсвийн хэмнэлт /хувь/	3	12.6	12.6	4.3	3
4	Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	46.4	42	61.5	60	67.8
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	78.2	81.6	88	90	92
6	Ажилгүйдлийн түвшин	14	4.6	11.7	10	8.6
7	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	143	183	249	340	204
8	Хэрэглээний үнийн индекс	2.2	5.3	5.5	6	2.6
9	Малын тоон өсөлт /хувь/	5	9.3	-2.6	5.7	12.3
10	Эрчимжсэн аж ахуйн тоо	2	2	3	16	31
11	Эрчимжсэн аж ахуй дахь малын тоо /мян.толгой/	30	107	500	257	0.782
12	Хураан авсан малын тэжээл, бусад таримал /мян.тн/	0.05	0.03	0.05	0.05	0.04

13	Хураан авсан хүнсний ногоо /мян.тн/	0.2	0.14	0.22	0.14	0.2
14	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо	350	530	355	394	475
15	Дэд бүтцэд холбогдсон орон сууцанд амьдарч буй иргэдийн хувь	42.4	42.4	43.2	43.2	43.4
ХҮН АМ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ						
16	Иргэний шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент=(шилжиж ирсэн хүн амын тоо-шилжиж явсан хүн амын тоо)/аймгийн хүн амын тоо)	3.8	8.9	5.7	4.6	4.1
17	Хүний хөгжлийн индекс	0.725	0.717	0.717	0.707	0.717
18	Жендерийн тэгш бус байдлын индекс	0.425	0.357	0.357	0.363	0.313
19	Бүртгэгдсэн гэмт хэрэг /бууралтын хувь/	1.9	14.7	2.9	12.5	3.9
20	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	34.7	31.3	38	30	68.2
21	Агаар дахь азотын давхар ислийн агууламж, мкг/м3	0.009	0.01	0.01	0.018	0.017
22	Агаар дахь хүхэрлэг хийн агууламж, мкг/м3	0.026	0.013	0.011	0.015	0.019
23	Эх, нялхсын эндэгдлийн түвшин	15.5	7.1	2.3	0	6.8
24	Халдварт өвчнөөр өвчлөгсдийн түвшин	176.7	141.6	134.6	11.7	37.9
25	Цэцэрлэгт хамрагдалтын хувь	83	86.7	85.3	94.2	95
26	Сургуульд хамрагдалтын хувь	100	98	100	100	100
27	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтын хувь	80.6	85.7	85.1	85.7	78.6
28	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	468.6	479.9	503.9	503.7	508.2
29	Шинээр ашиглалтад оруулсан цэцэрлэг, сургуулийн тоо	-	1	1	1	1

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах зорилгоор Монгол улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны

хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03–ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 05 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус батлан бодлогын 4 зорилтын хүрээнд үйл ажиллагаа, арга хэмжээгээ төлөвлөн хэрэгжүүлж байна.

“Аймгийн стратеги төлөвлөгөө”-ний үндсэн зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн дунд болон богино хугацааны дээрх бодлогын баримт бичгийг баримтлан, уялдуулан боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Улсын Их Хурлаар 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” болон нийтлэг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа 30 хуулийг удиртгал болгон “Мандатын шинжилгээ”-г Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд хийж ерөнхий 1, үндсэн 3, дэд 35, хамтран хэрэгжүүлэх 77 чиг үүргийг тодорхойлж, дараах хүснэгтээр харуулав.

Мандатын шинжилгээ хийхэд дараах хуулийг үндэслэл болгон авч үзлээ. Үүнд:

Хүснэгт.2

Хуулийн жагсаалт

Нийтлэг мөрдөгддөг хууль	Чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хууль
1. Монгол улсын Үндсэн хууль	1. Боловсролын тухай хууль
2. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2. Эрүүл мэндийн тухай хууль
3. Захиргааны ерөнхий хууль	3. Гамшгаас хамгаалах тухай хууль
4. Төсвийн тухай хууль	4. Нийгмийн халамжийн тухай хууль
5. Татварын ерөнхий хууль	5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
6. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
7. Хөдөлмөрийн тухай хууль	7. Усны тухай хууль
8. Зөрчлийн тухай хууль	8. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
	9. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
	10. Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
	11. Харилцаа, холбооны тухай хууль
	12. Эрчим хүчний тухай хууль

- 13. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- 14. Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- 15. Аялал, жуулчлалын тухай хууль
- 16. Хог, хаягдлын тухай хууль
- 17. Авто замын тухай хууль
- 18. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- 19. Газрын тухай хууль
- 20. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 21. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
- 22. Төрийн хяналт, шалгалтын тухай хууль

Хүснэгт.3

Мандатын шинжилгээ, чиг үүрэг

Чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		30
Үүнээс	Аймгийн Засаг даргад хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа хуулийн тоо	22
	Нийтлэг мөрдөгддөг хуулийн тоо	8
Ерөнхий чиг үүрэг -1: Аймаг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Үндсэн чиг үүрэг-1: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвөөс хуваарилуулах; 2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилах; 3. Орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж 	<p>Аймаг, сум</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгалийн баялгийн үр өгөөж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад боломжид түшиглэн хөгжих; 2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт 3. Аймаг, сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт; 4. Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;
Үндсэн чиг үүрэг -2: Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах	<p>Дэд чиг үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт; 2. Орон нутгийн өмчийн удирдлага; 3. Орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй; 4. Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж; 	<p>Аймаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Аймгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт; 2. Аймгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт 3. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт; 4. Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент

	<p>5. Худалдаа, үйлчилгээний зохицуулалт; 6. Дэд бүтэц 7. Орон сууц, нийтийн аж ахуй; 8. Орон нутаг дахь нийтийн тээвэр; 9. Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол; 10. Гудамж, талбайн нэр, хаягжуулалт; 11. Хөшөө дурсгалын зохицуулалт; 12. Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж; 13. Орон нутгийн аялал жуулчлалын бодлого, менежмент; 14. Хог хаягдлын менежмент; 15. Оршуулгын газрын зохицуулалт; 16. Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ; 17. Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу; 18. Орон нутгийн цэвэрлэх байгууламж; 19. Орон нутгийн зам, гүүр; 20. Суурин газрын гэрэлтүүлэг; 21. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт. 22. Хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ; 23. байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт; 24. Газрын харилцаа, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт</p>	<p>5. Малын тэжээлийн нөөц бүрдүүлэлт 6. Үйлдвэрлэлийн зориулалттай усан хангамж; 7. Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, түүний гамшгаас урьдчилан сэргийлэх, хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ; 8. Худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт; 9. Харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээний төлөвлөлт, ашиглалт, хамгаалалт 10. эрчим хүч, өндөр хүчдэлийн болон цахилгаан, дулааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагаа 11. Цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт; 12. Сум хоорондын нийтийн тээврийн зохицуулалт 13. Гудамж, талбайн нэр, хаягжилтын нийтлэг зохицуулалт; 14. Хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт; 15. Түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт 16. Аймгийн аялал жуулчлалын бодлого, менежмент; 17. Аюултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент; 18. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ. 19. Үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт 20. Бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт 21. Бэлчээрийн менежмент 22. Сургуулийн өмнөх боловсрол; 23. Ерөнхий боловсрол;</p>
--	--	---

		<p>24. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;</p> <p>25. Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах</p> <p>26. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, түүний хэрэгжилт;</p> <p>27. Соёлын үйлчилгээ;</p> <p>28. Нийтийн биеийн тамир;</p> <p>29. Ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, хэрэгжилт, хяналт;</p> <p style="text-align: center;">Сум</p> <p>1. Сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт</p> <p>2. Сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт</p> <p>3. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;</p> <p>4. Малын тэжээлийн нөөц бүрдүүлэлт</p> <p>5. Үйлдвэрлэлийн зориулалттай усан хангамж;</p> <p>6. Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, түүний гамшгаас урьдчилан сэргийлэх, хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ;</p> <p>7. Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;</p> <p>8. Худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт;</p> <p>9. эрчим хүч, өндөр хүчдэлийн болон цахилгаан, дулааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагаа</p> <p>10. Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага</p> <p>11. Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт;</p> <p>12. Хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;</p> <p>13. Түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт</p> <p>14. Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;</p> <p>15. Аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт;</p>
--	--	---

		<p>16. Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент;</p> <p>17. Оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт</p> <p>18. Сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;</p> <p>19. Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт;</p> <p>20. Орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт</p> <p>21. Орон нутгийн зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт;</p> <p>22. Суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт</p> <p>23. Бэлчээрийн менежмент</p> <p>24. Сургуулийн өмнөх боловсрол;</p> <p>25. Ерөнхий боловсрол;</p> <p>26. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;</p> <p>27. Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах</p> <p>28. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, түүний хэрэгжилт;</p> <p>29. Соёлын үйлчилгээ;</p> <p>30. Нийтийн биеийн тамир;</p> <p>31. Ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, хэрэгжилт, хяналт;</p> <p style="text-align: center;">Баг</p> <p>1. Хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах ажлын зохион байгуулалт;</p> <p>2. Улс, аймаг, сумын чанартай асуудлаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд багийн иргэдийг зохион байгуулж оролцуулах ажил;</p> <p>3. Хууль, зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй тохиолдолд багийн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх;</p> <p>4. Бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, тариалан, бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалт, зохицуулалт;</p> <p>5. Тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны тэнцвэрт байдалд</p>
--	--	---

		тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажил.
<p>Үндсэн чиг үүрэг -3:</p> <p>Иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх, гамшиг осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлж, нийгмийн хэв журмыг сахиулах</p>	<p>Дэд чиг үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр; 2. Мэргэжлийн хяналт 3. Онцгой байдлын болон гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа; 4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаа; 5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа; 6. орон нутгийн хамгаалалт; 7. Архивын ажил үйлчилгээ, төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалт, бүрдүүлэлт, ашиглалт 8. Улсын бүртгэл 	<p>Аймаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр; 2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих 3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх 4. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний бодлого, төлөвлөлт, хяналт
		<p>Сум</p> <ol style="list-style-type: none"> 1. Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих 3. Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаа 4. Иргэдэд анхан шатны төрийн үйлчилгээ үзүүлэх

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Хүн ам нь эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах орчин, нөхцөл бүрдсэн, хүний хөгжлийг хангасан аймаг болох.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэд бүтцийн давуу байдал, дэвшилтэт технологи, хүний хөгжил, олон нийтийн оролцоонд тулгуурлан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах замаар, иргэдийн ажиллах, амьдрах тав тухтай, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Говьсүмбэр аймгийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ болон аймгийн дунд, богино хугацааны бодлогын 4 зорилтын хүрээнд нэгтгэн гадаад, дотоод орчны давуу болон сул тал, боломж, эрсдэлийг тодорхойллоо.

ДОТООД ОРЧИН	
<p style="text-align: center;">Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> - Сургууль, цэцэрлэгийн хамран сургалт өндөр - Цэцэрлэг, сургуулийн барилга шинээр баригдан ашиглалтад орсноор суралцагчдад суралцах таатай орчин бүрдэж байна. - Элсэлтийн нийтийн шалгалтын Нийгмийн тухай мэдлэг, Монгол хэлний хичээлийн гүйцэтгэл өндөр - Орон нутагт их, дээд сургууль суралцагчдад сургуулийн хуваарь хангалттай ирдэг - Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр Олон Улсын байгууллагуудын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа сайжирч үр дүнд хүрсэн. - Аймгийн Нэгдсэн эмнэлгийн шинэ барилгатай болсноор эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх; - Төрөлжсөн мэргэшлийн болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг цаг алдалгүй авах; - Хүн амын хэрэглээнд үндэслэн амьжиргааны түвшинг тодорхойлдог “орлогыг орлуулан тооцох аргачлал”-ыг нэвтрүүлж, зорилтот бүлгийг тодорхойлж байгаа. Аргачлалыг боловсронгуй болгох зорилт тавьсан. - Ажилгүй иргэд, ажил хайгч иргэд, бусад зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хүргэж, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ. - Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. - Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ. - Хөдөлмөрлөх чадвартай боловч халамж хүртдэг иргэдийг бэлэн мөнгөөр тэтгэх бус хөдөлмөр хийж орлого олоход саад болж байгаа бэрхшээлийг нь хамтын дэмжлэгтэйгээр арилгаж, хөдөлмөрлөх нөхцөлийг нь бүрдүүлж, ядуурлаас гаргах олон салбарын хамтын ажиллагааг хөгжүүлнэ. “Халамж хүртэгчээс-хөдөлмөр эрхлэгч” болгох бодлогыг хэрэгжүүлнэ. - “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах бодлогын 	<p style="text-align: center;">Сул тал</p> <ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн 1 бүлэг хэт олон хүүхэдтэй, нэг хүүхдэд ногдох талбай бага - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай, багшлах боловсон хүчний туршлага, дутмаг, мэргэшээгүй - Насан туршдаа боловсрох, иргэдийн цаг ямагт хөгжих хэрэгцээ - Оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж хангалтгүй, чадавхи сул; - Хүн амын эрүүл мэндийн мэдлэг дутмаг; - Лабораторийн тусламж үйлчилгээний чадавхи сул; - Салбарын хүний нөөцийн хангалт дутагдалтай; - Ядуурлын түвшин өндөр - Ажилгүйдэл буурахгүй байна. - Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх үйлчилгээний хөгжил муу байна. - Халамжийн бодлого болон хөдөлмөрийн үнэлэмж бага байгаатай холбоотой иргэдийн хөдөлмөр эрхлэх идэвх, хандлага сул байна. - Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна. - Ажил хайж буй хүмүүсийн ур чадвар нь хөдөлмөрийн зах зээл дээр шаардлагатай байгаа ажлын байранд таарч нийцэхгүй, хөдөлмөр эрхлэлтийн бүтээмж бага байна. - Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж амьдрах сэдлийг бий болгох зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ хийдэггүй. - Гэрээний хугацаа дуусах үед дотоодын Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангаж ажилладаггүй - Өвлийн спорт хөгжүүлэх байгалийн болон материаллаг орчин нөхцөл бүрдээгүй

<p>хүрээнд иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэвтрүүлнэ. 	
ГАДААД ОРЧИН	
<p style="text-align: center;">Боломж</p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын насны бүтэц, хөдөлмөр эрхлэх идэвхтэй хүн амын эзлэх хувь - Орон нутагт дутагдалтай мэргэжлийн багшийг бодлогоор дэмжих - Багш, удирдлага, мэргэжилтнүүд мэргэжил ур чадвараа дээшлүүлэх - Эмчилгээ, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх; - Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх арга хэлбэрийг өөрчлөх; - Бүсийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх төв болох; - Шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах; - Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх; - Ёс зүй, харилцаа хандлагаа сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн уламжлалт ойлголт, хандлагыг өөрчилж, хүний эрхэд түшиглэсэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх, нийгмийн суурь үйлчилгээ хүртэх, суралцаж хөгжих, хөдөлмөрлөх зэрэг үндсэн эрхээ эдлэхэд бүтцийг сайжруулна. - Ажил хайгчдыг зах зээл дээр байгаа ажлын байранд илүү үр дүнтэйгээр зуучлах, ажил олгогчдыг мэргэжлийн боловсрол болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд түлхүү, шууд оролцуулна. - Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний чанарыг сайжруулснаар иргэд тохирсон ажлын байрандаа зуучлагдан ажлын байраар хангагдана. - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр иргэдийн мэргэжлийн ур чадвар дээшилж, хөдөлмөрлөх нөхцөл, боломжийг нэмэгдүүлнэ. - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэд дараагийн шатны хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах боломж бүрдэнэ. 	<p style="text-align: center;">- Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутагт бүртгэлгүй хүн ам - Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүрэлцээ хангалтгүй - Хүүхдүүд өөрсдийн чадвараа хөгжүүлэх орчин нөхцөл хангалтгүй. Сургалтын төвүүд, Хүүхэд хөгжлийн ордон байхгүй - Ерөнхий боловсролын сургуулиуд сэтгэл зүйчгүй. - Хавдар, осол гэмтэл, сүрьеэгийн өвчлөл, нас баралт буурахгүй; - Эмчилгээ, оношилгоонд антибиотек мэдрэг чанарыг тодорхойлох шинжилгээ хийгдэхгүй; - Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажиллахгүй; - Нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээ нь ядуурлыг бууруулахад чиглэгдэж байгаа боловч эдийн засгийн өсөлтийг дагаж ядуурлын хамрах хүрээ буурахгүй, харин ч ядуурал олон хэлбэртэй болж хүн амын зарим хэсэг нь орлогын төдийгүй боловсролын, сэтгэлгээний ядууралд нэрвэгдэж, ядууралтай эвлэрч, түүнээс гарах эрмэлзлээсээ няцах хандлагатай болж байна. - Бусдын дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай ганц бие өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асаргаа, сувилахуйн үйлчилгээ дутагдалтай байна - Орлогын тэгш бус байдал улам гүнзгийрч байна. Тухайлбал, иргэдийн банкин дахь хадгаламж нийт дүнгээр өсөж байгаа харагдавч хадгаламжийн нийт дүнгийн 80 хувь нь хадгаламж эзэмшигчдийн 3-хан хувьд оногдож байна. Иймд ядуурлыг бууруулах, иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэх асуудалд онцгой анхаарах шаардлагатай. - Төрөөс бодлогоор ажлын байр нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, жижиг, дунд бизнесийг дэмжих, иргэд өөртөө ажлын байр бий болгох арга хэмжээг тууштай авахгүй байгаагаас ажилгүйдэл, ядуурлын түвшин буурахгүй байна. - Ажил олгогчид насны хязгаар зааж, хөдөлмөрийн чадвартай иргэдэд ажил

<ul style="list-style-type: none"> - Жил бүр эрэлттэй байхаар тодорхойлогддог, ойрын ирээдүйд эрэлт нь өсөж буй ажил мэргэжлийн нийлүүлэлтэд анхааран, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, шийдвэрийг чиглүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна. - Хөдөлмөрийн нөөц дэх томоохон бүлэг болох бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлагагүй залуу ажиллах хүчинд чиглэсэн бодитой бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ өндөр байна. - Төрийн болон хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны зуучлалын үйл ажиллагааны олон талт хэлбэрийг сонгох, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна. - Хөдөлмөр эрхлэлт, зуучлалын төвийн үйл ажиллагааг олон нийтэд, тэр дундаа залуусын дунд байнга сурталчилна. - Дотоодын ажиллах хүчийг гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнийг дагалдуулан сургаж ажлын байраар хангана. 	<p>олдохгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд тохирсон ажлын байр ховор байгаа нь ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдийн боломжид саад учруулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн гаднах спортын болон тоглоомын талбай нь байгаль цаг уурын нөлөөллөөс болж хөрс гадны нөлөөнд хүчтэй өртөх эрсдэлтэй.
--	---

Хүснэгт.5

Эдийн засгийн бодлого, зорилтын хүрээнд

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Олон улсын Транзит төмөр зам, авто зам, агаарын коридор дайран өнгөрдөг. Баянтал суманд Оросын цэргийн ангийн ашиглаж байсан бүх төрлийн даацын онгоц хөөрч, буух зориулалт бүхий онгоцны буудалтай. - Олон улсын шилэн кабель дайран өнгөрдөг, аймаг, сумдын төв, хөдөөгийн багууд интернэт сүлжээнд холбогдсон, харилцаа холбооны 4G, IP технологи нэвтэрсэн. - Төвийн эрчим хүчний системд холбогдсон, зүүн болон говийн аймгуудыг эрчим хүчээр хангах гол зангилаа, эрчим хүчний түгээх, дамжуулах станцууд байрладаг. - Говийн болон зүүн аймгуудыг нефтийн бүтээгдэхүүн, шатах, тослох материалаар хангадаг нефть хангамжийн агуулахууд байрладаг. - Умард говийн гүвээт, халхын дундад талын усны сав газарт хамаарах гүний усны нөөцтэй, нутгийн хойд хэсгээр Хэрлэн гол дайран өнгөрдөг. - Улаанбаатар төмөр зам ХНН-ийн төмөр замыг түшиглэн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт ачиж буулгах талбайнууд, боловсруулах үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Өмнөговь, Дундговь аймгаас уул уурхайн 	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн төрөлжилт жигд биш, уул уурхайгаас хамаарсан эдийн засагтай. - Хүн амын төвлөрөл багатайгаас зах зээлийн багтаамж бага - Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн чадавх сул, томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийн эзлэх хувь бага. - Газар тариалангийн салбарын хөгжил сул, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал бага, технологи хоцрогдсон, байгаль, цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай. - Хүн амын хүнсний хэрэгцээний хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөгний хэрэгцээ дутагдалтай, эрчимжсэн аж ахуй сул хөгжсөн. - Гадаад, дотоод аялагчдын тоо ихсэж байгаа боловч үйлчилгээний байгууллагуудын хүрэлцээ дутмаг. - Аялал жуулчлалын үйл ажиллагаанд нэгдсэн менежмент дутмаг, аяллын бүтээгдэхүүн тодорхой биш. - Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, нийлүүлэлтийн сүлжээ бүрдээгүй.

<p>бүтээгдэхүүн, түүхий эдийг дамжуулан тээвэрлэдэг.</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн төвийн Сүмбэр суманд улсын нөөцийн төв байрладаг бөгөөд зүүн болон говийн аймгуудыг хангах өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэн хадгалдаг. - Хөдөө аж ахуйн салбарт онцлог бүхий “Сүмбэр” үүлдрийн каракуль хонийг өсгөдөг. - Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уул оршдог бөгөөд байгалийн болон түүхийн дурсгалууд, Боржигин өв соёлд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. - Сумдын төвд орон сууцны хүрэлцээ, хангамж сайн, нийт өрхийн 41.2 хувь нь цэвэр ус, дулаан хангамжид бүрэн холбогдсон нийтийн эзэмшлийн орон сууцанд амьдардаг. 	
ГАДААД ОРЧИН	
<p style="text-align: center;">Боломж</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэл Улаанбаатар хотоос 240 км алслагдсан, 4 аймгийн 6 сумтай хиллэдэг. Эрчим хүч, зам, харилцаа, дэд бүтэц бүрэн холбогдсон, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй байдлаас шалтгаалан зэргэлдээ аймгийн иргэд нийгмийн болон бусад үйлчилгээг авч байгаа зэргээс шалтгаалан цаашид улсын хэмжээнд эдийн засаг, хүн амын суурьшлын томоохон төв болон хөгжих боломжтой. - Чойр-Нялгын хүрэн нүүрсний сав газарт байрлах, улсын нүүрсний хэрэглээний 30 хувийг, төвийн эрчим хүчний хэрэглээний 50.9 хувийг нийлүүлдэг Шивээ-Овоогийн уурхай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус уурхайг түшиглэн өндөр хүчин чадлын цахилгаан станц байгуулах, нүүрс химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой. - Аймгийн хөгжлийн давуу талд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах боломжтой. - Малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэр, барилгын салбарт өсөлт бий болгох. - Дэд бүтцийн хөгжилд тулгуурлан эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, фермерийн аж ахуй эрхлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний каластерийг хөгжүүлэх боломжтой. - Байгалийн болон соёлын өвд тулгуурлан богино хугацааны аялал жуулчлалыг хөгжүүлэх, 	<p style="text-align: center;">Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> - Зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар муу, иргэдийн бизнес эрхлэх мэдлэг дадал, туршлага дутмагаас шалтгаалан жижиг, дунд бизнесийн үр ашиг дээшлэхгүй байна. - Хөрөнгө оруулалт, санхүүжилт дутагдалтай, мэргэжлийн боловсрол хүчний нөөц хомс зэргээс шалтгаалаг үйлдвэрлэл, үйлчилгээний хүчин чадал, цар хүрээг нэмэгдүүлэх, шинэ инноваци, технологийг нутагшуулах боломж хязгаарлагдмал байна. - Байгаль, цаг агаарын хүчин зүйл, бэлчээрийн даац хэтэрсэн зэргээс үүдэлтэй газар тариалан, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх эрсдэл өндөртэй. - өрсөлдөх чадварын судалгаагаар бизнес эрхлэх орчин, эдийн засгийн тэнхээ муу байгааг тодорхойлсон.

<p>Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аялал жуулчлалын улсын маршрутын дайран өнгөрөх гол төв болж эдийн засгийн бүтцийг солонгоруулах, аялал жуулчлалын үйлчилгээний салбарын өсөлтийг хангах, хүн амын амьжиргааны шинэ эх үүсвэрийг бий болгож, өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.</p> <p>- Дэд бүтцэд тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, барилгын материал, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломжтой.</p> <p>- Бүс нутгийг холбосон авто зам харилцааг сайжруулж, зах зээл, эдийн засгийг тэлэх</p>	
---	--

Хүснэгт.6

Засаглалын бодлого, зорилтын хүрээнд

ДОТООД ОРЧИН	
<p style="text-align: center;">Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц цомхон / 3 сум 10 багтай/ - Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх дэд бүтэц сайн хөгжсөн. - Сумдын төвүүд интернэт сүлжээнд холбогдсон. - Аймгийн төвийн гэрэлтүүлэг, камержуулалт хангалттай. - Гадаад, дотоод зөрчилдөөн, терроризмын аюулгүй. 	<p style="text-align: center;">- Сул тал</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамж өсөхгүй байна. - Төрийн байгууллагуудын барилга, байгууламжийн хүрэлцээ хангамж, ашиглалтыг сайжруулах шаардлагатай. - Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай. - Төрийн албаны хүний нөөц дутагдалтай, хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн ихэссэн, тогтворгүй. - Иргэдэд төрийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллийг хүргэх байдал дутагдалтай. - Хүн амын суурьшил, нягтаршилтай холбоотой хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, мэргэжил, мэдлэг, ур чадвартай хүний нөөц дутмаг. - Орон нутгийн хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллага дутагдалтай. - Гэмт хэргийн гаралт буурахгүй байна. - Замын хөдөлгөөний аюулгүй байдал - Гамшиг, ослын үед ажиллах чадавх сул
ГАДААД ОРЧИН	
<p style="text-align: center;">Боломж</p> <ul style="list-style-type: none"> - Дэд бүтцэд тулгуурлан төрийн байгууллагын мэдээ мэдээллийг олон сувгаар иргэдэд хурдан шуурхай хүргэх боломжтой. - Төрийн албаны цомхон байдалд тулгуурлан төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах боломжтой. - Төр- Иргэн- Төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, иргэдээр гүйцэтгүүлэх боломж бүрдсэн. 	<p style="text-align: center;">Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> - Хээрийн түймэр, гамшиг осол - Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг - Хүнд, ноцтой гэмт хэргийн өсөлт, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ - Кибер халдлага, мэдээллийн аюулгүй байдал сул

Хүснэгт.7 Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, зорилтын хүрээнд

ДОТООД ОРЧИН	
<p style="text-align: center;">Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> - Цөлжилтийн, биологийн төрөл зүйлийн, агнуур зохион байгуулалтын төрөлжсөн судалгаанууд хийгдсэн - Байгаль орчныг хамгаалах чиглэлээр урт хугацаанд баримтлах бодлогын баримт бичгээ баталсан - Чойрын богд уулын Байгалийн нөөц газартай. - Нийт газар нутгийн 25 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. - Сумдын гүний усны нөөц газрын орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, ашиглалтад хяналт тавьж байна. - Аргаль хонь болон бусад ховор амьтан ургамлын нөөцтэй. - Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэж байна. - Орон нутгийн төсөвт байгаль орчныг хамгаалах зардлыг тусган баталж, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж байна. 	<p style="text-align: center;">Сул тал</p> <ul style="list-style-type: none"> - Газрын доройтлын шинж тэмдэг хүчтэй илэрч байгаа - эргэлдээ аймгуудаас уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлттэй холбоотой хүнд даацын машины олон салаа шороон зам үүссэнээс хөрсний эвдрэл, элэгдэл ихэссэн. - Бэлчээрийн даац хэтэрсэн, гадаргын усны нөөц бага, усан хангамж муутай, - Аймаг, сумын төв, суурин газрын 1396 гаруй га эдэлбэр газар нь цэргийн зориулалттай хотхоны үлдэгдэл туурь балгасаар бохирлогдсон - Уур амьсгалын өөрчлөлт Хөдөө аж ахуйн зохисгүй ашиглалтын улмаас цөлжилт эрчимтэй явагдаж байгаа. - Хүн амын ундны усны хатуулаг, эрдэсжилт өндөртэй. - Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой салхитай өдрийн тоо нэмэгдэх, байгалийн аюулт үзэгдлийн давтамж өсөх, гадаргын болон гүний усны түвшин багасаж, булаг шанд ширгэж байна. - Ногоон байгууламж, ойн зурвасын хэмжээ хангалтгүй.
ГАДААД ОРЧИН	
<p style="text-align: center;">Боломж</p> <ul style="list-style-type: none"> - Судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран байгаль хамгаалах менежментийг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг үр дүнд хүргэх боломжтой. - Гүний усны нөөцийн судалгааг хийлгэн, аймаг, сумдын төв болон хөдөөгийн хүн амын ундны усны хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх - Дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгох, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг дэмжих замаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах. - Малын тоо толгойг зохистой түвшинд барьж, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийг өтгөрүүлэх, бэлчээрийн ургамлыг хамгаалах, төвийн ногоон байгууламж, ойн зурвасыг нэмэгдүүлэх замаар цөлжилтийг бууруулах. - Хүнд даацын тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах замаар хөрсний эвдрэлийг бууруулах. - Төв суурин газрын хог хаягдлын менежментийг сайжруулах, хот тохижилт, хог 	<p style="text-align: center;">Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн газар нутгийн хойд хэсгийн хөрс гадны нөлөөнд хүчтэй, урд хэсгийн хөрс маш хүчтэй өртөх эрсдэлтэй. - Усны нөөцийн ашиглалтын балансыг авч үзэхэд 2040 он гэхэд гүний усны ашиглалтын баримжаат нөөц дутагдах тооцоо гарсан. - Байгаль орчныг хамгаалах талаар хүн амын мэдлэг, мэдээллийн түвшин харилцан адилгүй байгаагаас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүн дээшлэхгүй байна. - Байгаль орчныг хамгаалах зардлын хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах

хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааны механизмыг бүрдүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хөрсний бохирдлыг бууруулах.

- Дэд бүтцийн давуу талд тулгуурлан инженерийн дэд бүтцийг өргөтгөж хүн ам, өрхийн усан хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийг нэгдсэн системд эрчимтэй холбох, дэвшилтэт технологит суурилсан нийтийн аж ахуйг хөгжүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулах.

- Хүн амын байгаль орчны боловсролыг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох замаар байгаль орчныг хамгаалах

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

1. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд: Хүний хөгжлийн бодлогыг дэмжиж, шинжлэх ухаан, инновацид тулгуурлан эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх.

2. Эдийн засгийн бодлогын хүрээнд: Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, инновацыг нутагшуулах замаар нэмүү өртөг шингэсэн уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, газар нутгийн байршил, зам тээвэр, харилцаа, холбоо, дэд бүтцийн давуу байдалд түшиглэсэн тээвэр, логистикийн нөөцөд тулгуурлан олон тулгуурт эдийн засгийн өсөлтийг хангах.

3. Засаглалын бодлогын хүрээнд: Тогтвортой, нэгдмэл гадаад, дотоод бодлогын хүрээнд төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурлан хүний эрх, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлж, гамшиг, осол, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог хэрэгжүүлэх замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

4. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд: Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахуйц байгаль орчинд ээлтэй шинжлэх ухаан, инноваци, дэвшилтэт технологийг дэмжих замаар уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлоос хамгаалж, иргэдийн эрүүл орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Хүснэгт.8

Говьсүмбэр аймгийн 2020-2024 онд хэрэгжүүлэх стратеги зорилт, арга хэмжээ

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2019 он	Зорилтот түвшин 2024 он	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх байгууллага
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: АЙМАГ НЬ ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АСУУДЛААР БИЕ ДААН ШИЙДВЭР ГАРГАХ, СУМДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ, ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ						
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ-1: ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ҮНДСИЙГ БҮРДҮҮЛЭХ						
Зорилт -1 Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах	Цахим татварын системийг нэвтрүүлэн иргэд, татварын үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг хангах замаар татварын баазыг нэмэгдүүлнэ.	Цахим татварын хандалтын хувь ААНБ-ын тоо Иргэдийн тоо Хуулийн этгээдийн тоо Улс, орон нутгийн татварын орлогын биелэлтийн хувь	Систем нэвтрэлтийн хувь 70 625 100	Цахим татварын хандалтын хувь - ААНБ-90 Иргэд-50 656 100	БТ	ТХ
	Төрийн албаны цалингийн нэгдсэн системд төсвийн нийт байгууллагыг бүрэн хамруулж, цалин хөлсний гүйлгээний үйл ажиллагааг түргэн шуурхай гүйцэтгэнэ.	Хамрагдсан байгууллагын тоо	Хамрагдсан байгууллагын тоо 49	Хамрагдсан байгууллагын тоо 54	БТ	Төсвийн байгууллагууд
	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төрөөс	Хугацаандаа мэдээ оруулалтын хувь: Мэдээллийн үнэн зөв байдалд хяналт	95.9	97.0	БТ	СХАА

	татаас авч буй хувийн цэцэрлэгүүдийн шилэн дансны цахим хуудсанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.	шалгалт хийсэн байгууллагын тоо:	-	81		
Зорилт-2: Татварын тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Татварын тухай хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, хяналт тавьж, үр дүнг тайлагнах.	Төлөвлөгөөний биелэлтийн хувь Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	96.4 95	100.0 100	БТ	ТХ
1	Боловсролын тухай хууль	<p>20 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох байгууллага</p> <p>20.1.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллежид, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.</p>	<p>30 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>30.1.2.иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;</p> <p>30.1.3.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх;</p> <p><i>/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i></p> <p>30.1.4.өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах;</p> <p><i>/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>30.1.5.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;</p> <p>30.1.11.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр томилох, чөлөөлөх;</p> <p>30.1.12.үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>30.1.13.цэцэрлэгийг зориулалтын барилга байгууламжаар, ерөнхий боловсролын сургуулийг хичээлийн болон дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний</p>	<p>31 дүгээр зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>31.1.Сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>31.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>31.1.12.аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх;</p> <p>31.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p>31.2.Дүүргийн Засаг дарга тухайн дүүргийн боловсролын хэлтсийн даргыг нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн нийслэлийн боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.</p>	<p>32 дугаар зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>32.1.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>32.1.1.сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах;</p> <p>32.1.2.иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>32.1.3.суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах.</p>

			хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 30.1.16.хуульд заасан бусад бүрэн эрх.		
2	Эрүүл мэндийн тухай хууль	<p>11 дүгээр зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх</p> <p>11.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>11.1.2.харьяалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>11.1.3.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах;</p> <p>11.1.4.байгалийн онц аюултай үзэгдэл болон олон улсын хөл хориот өвчин гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг шуурхай авах;</p> <p>11.1.5.эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;</p> <p>11.1.6.аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлөх;</p> <p>11.1.7.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай</p>	<p>12 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын бүрэн эрх</p> <p>12.1.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>12.1.2.улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах;</p> <p>12.1.3.эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах;</p> <p>12.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;</p> <p>12.1.5.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.</p> <p>12.2.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.</p>		

		<p>ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>11.1.8.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох;</p> <p>11.1.9.тухайн шатны нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөх;</p> <p>11.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>11.2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.2.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>11.2.2.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;</p> <p>11.2.3.эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>11.2.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжүүлэх;</p> <p>11.2.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>11.3.Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.</p> <p>19 дүгээр зүйл.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох</p> <p>19.2.Улсын хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн бусад</p>		
--	--	--	--	--

		байгууллагад аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага” гэх/ олгоно.			
3	Гамшгаас хамгаалах тухай хууль	<p>17 дугаар зүйл. Голомтын бүс тогтоох 17.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр, объектод хор уршгийг арилгах арга хэмжээг шууд удирдан зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;</p> <p>21 дүгээр зүйл. Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа 21.2.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардлыг улсын хэмжээнд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.</p> <p>22 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт 22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссыг тухайн</p> <p>23 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага 23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.</p> <p>23.3.Улсын онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.</p> <p>36 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг 36.3.Сайн дурын хэсэг нь тухайн шатны Засаг даргад гамшгаас хамгаалах</p>	<p>32 дугаар зүйл. Засаг даргын бүрэн эрх 32.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 32.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх; 32.1.2.нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох; 32.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах; 32.1.4.гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах; 32.1.5.хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах; 32.1.6.нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах; 32.1.7.гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах; 32.1.8.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах; 32.1.9.гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах;</p>	<p>13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах 13.3.3.сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга;</p>	<p>13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах 13.3.4.иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга; 32 дугаар зүйл. Засаг даргын бүрэн эрх 32.2.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p>

		<p>чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаагаа тайлагнана.</p>	<p>32.1.10.орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх; 32.1.11.харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах; 32.1.12.гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; 32.1.13.тухайн шатны Засаг дарга нь төв, орон нутагт томилогдон ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтныг албан тушаалын орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх. 32.1.14.онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум, суурин газарт гамшгаас хамгаалах асуудлыг Засаг даргын тамгын газрын аль нэг албан тушаалтанд хавсран гүйцэтгүүлнэ.</p>		
4	<p>Нийгмийн халамжийн тухай хууль</p>	<p>19 дүгээр зүйл.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ 19.4.Энэ хуулийн 19.2.1-19.2.4-т заасан хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана. 23 дугаар зүйл.Нийгмийн халамжийн асуудал эрхлэх байгууллага 23.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ. 24 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, хяналт 24.3.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний</p>			

		байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга тухайн шатны Засаг дарга тай зөвшилцөн томилж, чөлөөлнө.			
5	Төсвийн тухай хууль	<p>14 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх 14.1.17.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн.</p> <p>29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төсөвлөлт 29.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах; 29.3.2.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах; 29.3.3.нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах; 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах; 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.</p> <p>34 дүгээр зүйл.Төсвийн тодотгол 34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:</p>	<p>8 дугаар зүйл.Төсвийн цаглабар 8.5.1.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх; 8.5.5.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх. 8.7.1.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батлах; 8.7.2.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.</p> <p>15 дугаар зүйл.Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх 15.2.Энэ хуулийн 39.1-д заасан гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.</p> <p>27 дугаар зүйл.Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага 27.5.Орон нутгийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг төсвийн удирдамжид тусган, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.</p> <p>36 дугаар зүйл.Төрийн сангийн тогтолцоо</p>	<p>8 дугаар зүйл.Төсвийн цаглабар 8.5.3.сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх; 66 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх 66.1.Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 66.1.1.тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах; 66.1.2.орон нутаг дахь төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх; 66.1.3.аймаг, нийслэлийн Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах; 66.1.4.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх; 66.1.5.энэ хуулийн 39.2-т заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь тасралтгүй бүрэн санхүүжүүлэх; 66.1.6.сум, дүүргийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэх; 66.1.7.тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.</p>	<p>63 дугаар зүйл.Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах 63.1.Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.</p>

	<p>34.2.1.дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;</p> <p>34.2.2.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;</p> <p>34.2.3.энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах.</p> <p>39 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ</p> <p>39.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргатай энэ хуулийн 39.1-д заасан гэрээг сум, дүүргийн түвшинд аймаг, нийслэлийн төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.</p> <p>39.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана:</p> <p>39.4.1.тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутгийн төсвийн суурь зарлага болон бусад салбарын санхүүжилтэд шилжүүлэхгүй байх;</p> <p>39.4.2.өр, авлага үүсгэхгүй байх;</p> <p>39.4.3.үйлчилгээний стандарт, тоо хэмжээ, чанар, хүртээмжийг бууруулахгүй байх.</p> <p>42 дугаар зүйл.Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх</p> <p>42.3.3.зохицуулалт хийх санал нь улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт хамаарахаар бол төсвийн ерөнхийлөн захирагч нь саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн төсөвт хамаарахаар бол саналаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тус тус хүргүүлэх;</p> <p>61 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх</p>	<p>36.4.Энэ хуулийн 36.3-т заасан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх алба байгуулах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.</p> <p>39 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ</p> <p>39.1.Энэ хуулийн 14.1.6, 14.1.8-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.</p> <p>41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>41.6.Санхүүжилтийн түр горим, түүнийг хэрэгжүүлэх төсвийн сар улирлын хуваарийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоон, мөрдүүлнэ.</p> <p>56 дугаар зүйл.Төсвийн шатлал хоорондын харилцаа</p> <p>56.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг дараах зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхтэй:</p> <p>56.3.1.төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн;</p> <p>56.3.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн төсвөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан;</p> <p>56.3.3.тусгай зориулалтын шилжүүлгийн зориулалт, зарцуулалтын нөхцөл, шаардлагыг зөрчсөн;</p> <p>56.3.4.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний</p>		
--	--	---	--	--

	<p>61.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p>67 дугаар зүйл.Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх</p> <p>67.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p>67.2.Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:</p> <p>67.2.1.орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;</p> <p>67.2.2.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;</p> <p>67.2.3.аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;</p> <p>67.2.4.дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.</p> <p>67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.</p>	<p>стандартыг мөрдөөгүйгээс нийт төсөв нь алдагдалтай гарсан;</p> <p>56.3.5.орон нутгийн төсвийн тогтвортой байдал алдагдсан;</p> <p>56.3.6.орон нутгийн төсвийг энэ хуулиар тогтоосон хугацаанд батлаагүй.</p> <p>56.6.Энэ хуулийн 56.3-т заасан зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилт болон орон нутгийн төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн харилцаанд оролцогчдын чадавхийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газар болон аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>61 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх</p> <p>61.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ:</p> <p>61.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэнэ.</p> <p>61.1.1.сургуулийн өмнөх боловсрол;</p> <p>61.1.2.ерөнхий боловсрол;</p> <p>61.1.4.эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;</p> <p>61.1.5.газрын харилцаа, кадастр;</p> <p>61.1.6.хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ;</p> <p>62 дугаар зүйл.Орон нутгийн хэрэгцээнд зориулж өр үүсгэх</p> <p>62.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 41.5,-д заасан зориулалтаар улсын төсвөөс тухайн төсвийн жилийн дотор эргэн төлөгдөх нөхцөлтэй өр үүсгэж болно.</p> <p>65 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>65.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>		
--	---	--	--	--

		<p>65.1.1.тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;</p> <p>65.1.2.орон нутаг дахь төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;</p> <p>65.1.3.холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах;</p> <p>65.1.4.орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах;</p> <p>65.1.5.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг энэ хуулийн 8.5.5-д заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>65.1.6.энэ хуулийн 39.1-д заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь, тасралтгүй бүрэн санхүүжүүлэх;</p> <p>65.1.7.аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж, мөрдүүлэх;</p> <p>65.1.8.тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.</p>		
		<p>77 дугаар зүйл.Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх</p> <p>77.1.Татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.</p> <p>77.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтэс татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, дүүргийн</p>		

6	Татварын ерөнхий хууль	<p>татварын хэлтэс, сумын татварын хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагч нь аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн удирдлага доор тус тус ажиллана.</p> <p>77.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, төсөв хөрөнгөөр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.</p> <p>77.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.</p> <p>77.5.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.</p> <p>77.6.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг санхүү, эдийн засаг, эсхүл нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй иргэнийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.</p>			
7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	<p>78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх</p> <p>1. Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.</p> <p>2.Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;</p> <p>2/ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;</p> <p>3/ орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын Тэргүүлэгчдэд оруулах;</p> <p>4/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;</p>			

		<p>5/ орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах;</p> <p>6/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах;</p> <p>7/ нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах.</p>			
8	Усны тухай хууль	<p>7 дугаар зүйл.Усны мэдээллийн сан, тоо бүртгэл</p> <p>7.3.Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.</p>	<p>12 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>12.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх;</p> <p>12.1.2.улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгааны захиалга гаргаж, байгаль орчны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;</p> <p>12.1.3.ус, усан орчинг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>12.1.4.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах;</p> <p>12.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>	<p>13 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>13.1.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 12.1.1, 12.1.3-т зааснаас гадна усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.1.усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох;</p> <p>13.1.2.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>13.1.3.усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;</p> <p>13.1.4.мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтоох;</p> <p>13.1.5.энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгох;</p> <p>13.1.6.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийг мөрдүүлэх;</p> <p>13.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.</p>	<p>13 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>13.1.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 12.1.1, 12.1.3-т зааснаас гадна усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.1.усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох;</p> <p>13.1.2.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>13.1.3.усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;</p> <p>13.1.4.мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтоох;</p> <p>13.1.5.энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгох;</p> <p>13.1.6.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийг мөрдүүлэх;</p> <p>13.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.</p>

9	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	<p>19 дүгээр зүйл.Төрийн архивыг харьяалах байгууллагын чиг үүрэг, төрийн архивын удирдлагыг томилох, чөлөөлөх</p> <p>19.3.Аймаг, нийслэлийн архивын даргыг тухайн шатны Засаг дарга архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.</p>	<p>5 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх</p> <p>5.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга архив, албан хэрэг хөтлөлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.5.1.архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.5.2.архивыг зориулалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> <p>5.5.3.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>		
10	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	<p>7 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо</p> <p>7.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар удирдана.</p> <p>8 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч</p> <p>8.1.10.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга;</p> <p>9 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг</p> <p>9.10.4.Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.10.5.Засаг дарга энэ хуулийн 9.10.1, 9.10.2, 9.10.3, 9.10.4-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ хуулийг дагаж мөрдөх.</p> <p>17 дугаар зүйл.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн цаглавар</p> <p>17.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ.</p>	<p>15 дугаар зүйл.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн цаглавар</p> <p>15.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд суурилсан Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан захиргааны байгууллагатай хамтран өмнөх төлөвлөгөөний баримт бичиг дуусгавар болохоос нэг жилийн өмнө боловсруулна.</p> <p>17 дугаар зүйл.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн цаглавар</p> <p>17.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хууль тогтоомжид заасан хугацаанд танилцуулна.</p> <p>21 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ</p> <p>21.6.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг,</p>		

			нийслэлийн Засаг дарга ас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.		
11	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль	18 дугаар зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх 18.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ. 18.3.Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай саналаа боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.			
12	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	15 дугаар зүйл.Халдварт өвчнийг оношлох, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх 15.5.Хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчний талаар мэдээлэл хүлээн авсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь үйл ажиллагааг нэн даруй хэрэгжүүлнэ: 15.5.1.энэ хуулийн 17.2, 18.1, 18.3-т заасны дагуу дэглэм тогтоож, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл хориглох; 15.5.2.энэ хуулийн 16.1.1-16.1.3-т заасан бүс дэх мал, гэрийн тэжээвэр болон зэрлэг амьтны байршил, нягтаршил, хөдөлгөөнийг тандах ажиллагааг зохион байгуулах. 19 дүгээр зүйл.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн баг, ангийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа 19.1.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн багийг малын эмчээр ахлуулан тухайн сум, нийслэлийн Засаг дарга томилно. 23 дугаар зүйл.Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээ 23.6.Хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэх байршлыг тухайн шатны мал эмнэлгийн улсын байцаагчийн	23 дугаар зүйл.Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээ 23.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2-т заасны дагуу, энэ хуулийн 23.2-т заасан хамтарсан зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлнэ.	7 дугаар зүйл.Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэх 7.3.3.сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах; 7.3.4.гудамж, талбай, цэцэрлэг болон нийтийн эзэмшлийн газар үхсэн мал, амьтны талаархи иргэн, байгууллагаас мэдээлэл хүлээн авсан харьяалах хорооны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж /цаашид "гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж" гэх/-тэй хамтран цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, шаардлагатай үед сорьц авч лабораторид хүргүүлэх;	9 дүгээр зүйл.Дархлаажуулалтын ажил зохион байгуулах 9.4.Дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоож, баг, хорооны Засаг дарга малчин, амьтан маллагчид зарлан мэдээлнэ.

		дүгнэлтийг үндэслэн Засаг дарга тогтооно.		
13	Харилцаа холбооны тухай хууль	<p>7 дугаар зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх</p> <p>7.1.Бүх шатны Засаг дарга харилцаа холбооны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.1.нутаг дэвсгэртээ харилцаа холбооны үйлчилгээг сайжруулах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;</p> <p>7.1.2.аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, талбай, барилга, орон сууц, хашааг хаягжуулах арга хэмжээ авах;</p> <p>7.1.3.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас харилцаа холбооны сүлжээнд гарсан осол, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулах;</p> <p>7.1.4.радио, телевизийн болон харилцаа холбооны бусад сүлжээ байгуулж, ашиглах санаачлагыг дэмжих, туслалцаа үзүүлэх;</p> <p>7.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>		
14	Эрчим хүчний тухай хууль	<p>7 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаархи бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>7.3.Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга, байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, мод, бут, сөөгийг зайлуулах, дээрх зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авна.</p> <p>33 дугаар зүйл.Шугам сүлжээний хамгаалалтын зурвас</p> <p>33.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулна.</p>	<p>9 дүгээр зүйл.Зохицуулах хорооны бүрэн эрх</p> <p>9.1.12.аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гишүүдийг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;</p>	

15	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль	<p>9 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүрэг</p> <p>9.3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах эрхтэй байна:</p> <p>9.3.1.харьяа нутаг дэвсгэрийнхээ нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсоолын байршлыг тогтоох, өөрчлөх;</p> <p>9.3.2.зам, түүний ойролцоо худалдаа, үйлчилгээ явуулах, уралдаан, тэмцээн, жагсаал, цуглаан, бусад арга хэмжээ зохион байгуулахад зөвшөөрөл олгох;</p> <p>9.3.3.тухайн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн зөрчилд шийтгэл хүлээлгэх ажлыг зохион байгуулах.</p> <p>9.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.4.1.зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;</p> <p>9.4.2.замын хөдөлгөөний түгжрэл, саатлын шалтгаан, нөхцөлийг судалж, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>9.4.3.иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;</p> <p>9.4.4.тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэнд замыг цэвэрлэх, бохирдол, цас мөсийг арилгахыг үүрэг болгох;</p> <p>9.4.5.харьяа нутаг дэвсгэрийнхээ зам, замын байгууламж гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчил, иргэдийн санал, гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авахуулах;</p> <p>9.4.6.зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах, тоноглох, замын гэрэлтүүлэг, тэмдэг, тэмдэглэл</p>	<p>9 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүрэг</p> <p>9.5.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний акт гаргаж болно.</p>	
----	---	---	--	--

		хийх ажил нь холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний акт, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах; 9.4.7.харьяа нутаг дэвсгэрийнхээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жилд хоёроос доошгүй удаа тайлагнах.			
16	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	<p>31 дүгээр зүйл.Соёлын биет өвийг эзэмших</p> <p>33.2.5.алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;</p> <p>37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо</p> <p>37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.</p> <p>37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.</p> <p>39 дүгээр зүйл.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах</p> <p>39.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлөн уламжлуулах, хадгалж хамгаалах асуудлыг хариуцна.</p> <p>39.3.Соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, шавь сургалт зохион байгуулах асуудлыг бүх шатны Засаг дарга зохион байгуулна.</p>	<p>6 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>16.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.2.соёлын өвийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.3.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.4.соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, аймаг, нийслэл, улсын бүртгэл, мэдээллийн санд хүргүүлэх;</p> <p>16.1.5.зохих журмын дагуу соёлын өвийн үзлэг, тооллого хийх;</p> <p>16.1.6.соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах;</p> <p>16.1.7.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх;</p> <p>16.1.8.соёлын өвийг сурталчлах;</p> <p>16.1.9.дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг</p>	<p>17 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>17.1.Сум, дүүргийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>17.1.2.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>17.1.3.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, багт зориулалт бүхий газрыг ашиглуулах;</p> <p>17.1.4.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгааны ажил дууссаны дараа судалгаа явуулсан байгууллагаас уг газрыг аюул осолгүй болгохыг шаардах, хүлээн авах.</p> <p>37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо</p> <p>37.4.Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.</p> <p>38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа</p> <p>38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.</p> <p>45 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт газар</p> <p>45.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.</p> <p>58 дугаар зүйл.Соёлын өвийн хяналт</p>	<p>19 дүгээр зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>19.1.Баг, хорооны Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>19.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>19.1.2.палеонтологи, археологийн хууль бус хайгуул, малтлагыг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх талаар холбогдох албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх;</p> <p>19.1.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний орчныг цэвэр үзэмжтэй байлгах, хог хаягдлыг цэвэрлэхэд иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>19.1.4.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хуульд заасны дагуу урамшуулах, дэмжлэг үзүүлэх, дээд шатны байгууллагад уламжлах;</p> <p>19.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>

	<p>40 дүгээр зүйл.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах 40.3.Энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулд борлуулалтын орлогын 15 хувийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p> <p>58 дугаар зүйл.Соёлын өвийн хяналт 58.1.Соёлын өвийн хяналтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, улсын байцаагч, гэрээт харуул хэрэгжүүлнэ. <i>/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх; 16.1.10.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хуульд заасан дэмжлэг үзүүлэх; 16.1.11.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах ажлыг удирдан зохион байгуулах; 16.1.12.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах; 16.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p>26 дугаар зүйл.Соёлын өвийн үзлэг, тооллого 26.1.Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.</p> <p>37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо 37.5.Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд тухайн дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, байрлуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.</p>	<p>58.5.Соёлын өвийн гэрээт харуулыг сум, дүүргийн Засаг дарга томилно.</p>	
--	---	---	--	--

17	Аялал жуулчлалын тухай хууль	<p>15 дугаар зүйл. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо</p> <p>15.7. Бүх шатны Засаг дарга аялал жуулчлал хөгжүүлэх эрэлт хэрэгцээг харгалзан аялал жуулчлалын асуудал эрхэлсэн нэгж /ажилтан/-ийг ажиллуулж болно.</p> <p>18 дугаар зүйл. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх</p> <p>18.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>18.2.1. аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, зохион байгуулах;</p> <p>18.2.2. эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн газар нутагт байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;</p> <p>18.2.3. нутаг дэвсгэртээ аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөтөлбөр, төсөл боловсруулж, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>18.2.4. нутаг дэвсгэрээрээ дайран өнгөрч яваа жуулчдаас хуульд зааснаас бусад тохиолдолд татвар, төлбөр, хураамж авахгүй байх.</p> <p>22 дугаар зүйл. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт</p> <p>22.2. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг төрийн захиргааны төв байгууллагууд, бүх шатны Засаг дарга нар эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.</p>			
----	------------------------------	--	--	--	--

18	Хог хаягдлын тухай хууль	<p>10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг</p> <p>10.2.15. хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;</p> <p>13 дугаар зүйл. Хог хаягдалтай холбогдох үйл ажиллагаанд тавих хяналт</p> <p>13.1. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд улсын мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан хяналт тавина.</p> <p>42 дугаар зүйл. Хог хаягдлын талаархи боловсрол олгох</p> <p>42.3. Хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалтыг орон нутагт зохион байгуулж, иргэдийг сургалтад бүрэн хамруулахад бүх шатны Засаг дарга санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.</p> <p>42.4. Хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санаачлагаар хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт зохион байгуулахад сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга болон нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь сургалтын талбай, байраар дэмжлэг үзүүлэх, иргэдийн оролцоог хангахад туслалцаа үзүүлнэ.</p>	<p>9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх</p> <p>9.3. Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.3.1. хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p> <p>9.3.2. энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;</p> <p>9.3.3. энэ хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл олгох журмыг батлах;</p> <p>9.3.4. хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийн биелэлтийг хангах;</p> <p>9.3.5. энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх;</p> <p>9.3.6. хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p> <p>9.3.7. нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>9.3.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, олон улсын зээл, тусламжаар байгуулсан хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, булшлах, устгах байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;</p> <p>9.3.9. хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</p>	<p>9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх</p> <p>4. Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.4.1. нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;</p> <p>9.4.2. энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;</p> <p>9.4.3. нутаг дэвсгэрт хамаарах олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замын байгууламж болон авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.4.2-т заасны дагуу зохион байгуулах;</p> <p>9.4.4. хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулах;</p> <p>9.4.5. нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх;</p> <p>9.4.6. энэ хуулийн 42.3, 42.4-т заасан хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;</p> <p>9.4.7. хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах;</p> <p>9.4.8. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;</p> <p>9.4.9. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.4.10. энэ хуулийн 9.5.7-д заасан иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.4.11. нийтийн эдэлбэр газарт хогийн савыг хүртээмжтэй тоогоор байрлуулах;</p> <p>9.4.12. нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох;</p> <p>9.4.13. энэ хуулийн 9.3.11-д заасан эрхийг хэрэгжүүлэх;</p> <p>9.4.14. энэ хуулийн 9.3.12-т заасан журмын дагуу ажиллах хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг жил бүрийн</p>	<p>9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх</p> <p>9.5. Хог хаягдлын талаар баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.5.1. нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;</p> <p>9.5.2. хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;</p> <p>9.5.3. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;</p> <p>9.5.4. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.5.5. хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>9.5.6. хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;</p> <p>9.5.7. хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах.</p>
----	--------------------------	---	---	--	---

		<p>9.3.10. хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирсан эсхүл болзошгүй аюул үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тархалтыг зогсоох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах;</p> <p>9.3.11. нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг шийдвэрлэх;</p> <p>9.3.12. хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг батлах;</p> <p>9.3.13. хууль тогтоомжид заасан бусад.</p> <p>31 дүгээр зүйл. Байгууламжийг хаах</p> <p>31.3. Байгууламжийг хэсэгчлэн болон бүрэн хаах тухай мэдэгдлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхээс 90 хоногийн өмнө мэдэгдэнэ.</p> <p>31.6. Байгууламжийг бүрэн хааснаас хойш 60 хоногийн дотор байгууламжийг хаасан мэдэгдэл, тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.</p> <p>32 дугаар зүйл. Хаалтын дараахь хяналт-шинжилгээ</p> <p>32.4. Энэ хуулийн 32.2-т заасан хяналт-шинжилгээгээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц хэмжээгээр шүүрэл, ялгарал үүсэж байгаа нь тогтоогдвол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.</p>	<p>төсөвт тусгаж, батлуулах, зарцуулалтад хяналт тавих.</p> <p>14 дүгээр зүйл. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх</p> <p>14.2. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.</p> <p>14.4. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.</p> <p>41 дүгээр зүйл. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, төлбөр, үйл ажиллагааны санхүүжилт</p> <p>41.13. Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож сум, дүүргийн Засаг дарга мөнгөн урамшуулал олгоно.</p>	
--	--	---	---	--

19	Авто замын тухай хууль	<p>12 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>12.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга авто замын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;</p> <p>12.1.2.авто замын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх;</p> <p>12.1.3.нийслэл, орон нутгийн чанартай авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.4.нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах авто замын барилга, засвар, арчлалтын ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.5.олон улс, улсын болон орон нутгийн чанартай, тусгай зориулалтын авто замын бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах талаар харьяа нутаг дэвсгэрийн байгууллага, иргэнд үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах;</p> <p>12.1.6.нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах, талаар журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хэрэгжүүлэх;</p> <p>12.1.7.байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах шаардлага гарсан үед харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан гаргуулах, хүн хүчний тусалцаа авах ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.8.харьяа нутаг дэвсгэртээ авто замын хөдөлгөөнийг зохих хууль,</p>	<p>14 дүгээр зүйл. Авто замын сүлжээ</p> <p>14.3.Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.</p> <p>14.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 14.3-т заасан төлөвлөгөөг боловсруулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.</p> <p>16 дугаар зүйл. Авто замын бүрэлдэхүүн</p> <p>16.3.Нийслэл болон хот, суурингийн авто замын зурвас газрын өргөнийг холбогдох норм, дүрмийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.</p> <p>16.4.Онцгой тохиолдолд олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөнийг тухайн авто зам болон газар нутгийн онцлогтой уялдуулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын зурвас газрын өргөнийг аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох норм, дүрмийн хүрээнд өөрөөр тогтоож болно.</p> <p>16.5.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын хяналт тавих зурвас газрын хэмжээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын хяналт тавих зурвас газрын өргөнийг зураг төслийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.</p> <p>17 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийн өмчлөгч, эзэмшигч</p> <p>17.3.Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг,</p>		
----	------------------------	---	--	--	--

	<p>журмын дагуу зохион байгуулах, зохицуулах; 12.1.9.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч тусгах.</p> <p>15 дугаар зүйл. Авто замын ангилал 15.4.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг тухайн шатны Засаг дарга авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно.</p> <p>34 дүгээр зүйл. Авто замын улсын хяналт 34.1.Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг авто замыг өмчлөгч, эзэмшигч, зам хариуцагч байгууллага, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.</p>	<p>нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон этгээд байна.</p> <p>18 дугаар зүйл. Авто замын техник, эдийн засгийн үндэслэл 18.2.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга, бусад авто замын хувьд тухайн авто замын захиалагч батална.</p> <p>24 дүгээр зүйл. Авто замын сан 24.9.Тухайн жилд улсын авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус баталж, хэрэгжүүлнэ.</p> <p>27 дугаар зүйл. Авто замын бүртгэл, мэдээллийн сан 27.2.Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг аймаг, нийслэлийн Засаг дарга эрхлэн хөтөлнө.</p> <p>27.4.Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.</p> <p>28 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах</p>		
--	--	---	--	--

			<p>28.1.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглалтад авах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.</p> <p>30 дугаар зүйл. Авто зам, замын байгууламж ашигласны төлбөр</p> <p>30.3.Нийслэл, орон нутгийн чанартай болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.</p>		
20	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	<p>4 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг</p> <p>4/байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.</p> <p>6 дугаар зүйл.Байгалийн баялгийг өмчлөх, байгаль орчныг хамгаалах</p> <p>5.Засаг дарга энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс тухайн нутгийн байгаль орчинд онц их хэмжээний хохирол учирсныг эрх бүхий мэргэжлийн байгууллага хуульд заасан аргачлалаар албан ёсоор тогтоосон тохиолдолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.2-т заасан арга хэмжээ авна.</p> <p>10¹ дүгээр зүйл.Байгаль орчны аудит</p> <p>2.Байгаль орчны аудит хийх зардлыг төлөвлөгөөт хугацаанд хийж байгаа тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага, төлөвлөгөөт бус хугацаанд Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд захиалагч тал хариуцна.</p>	<p>16 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;</p> <p>3/байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;</p> <p>4/хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;</p> <p>5/байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх.</p> <p>6/шинээр томилогдсон Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн</p>	<p>17 дугаар зүйл.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;</p> <p>4/байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайлан хэлэлцэх.</p> <p>5/нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдвэрлэх.</p> <p>6/энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасан үнэлэлт, дүгнэлт өгч байх;</p> <p>7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг хянах.</p> <p>2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>18 дугаар зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах;</p> <p>2/нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;</p> <p>3/байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох.</p> <p>4/нөхөрлөл байгуулах талаар багийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэх.</p> <p>2.Баг, хорооны Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах;</p>

	<p>11 дүгээр зүйл.Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт 2.Төрийн захиргааны төв байгууллага, зохих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.</p> <p>22 дугаар зүйл.Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг 3.Байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас сэргийлэх, түүний эх үүсвэрийг хязгаарлах, хор уршгийг арилгах, байгаль орчныг засаж сайжруулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага, иргэний хамгаалалтын алба, бүх шатны Засаг дарга, холбогдох бусад байгууллага хамтран авч хэрэгжүүлнэ.</p> <p>28 дугаар зүйл.Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг 5/байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;</p> <p>30 дугаар зүйл.Мэргэжлийн байгууллага 7/байгалийн баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, шаардлагатай бол төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;</p> <p>31 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг 8/хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэхийг Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас шаардах;</p> <p>32 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох</p>	<p>санг энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-6 дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэж хүлээлгэн өгөх бөгөөд түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч байна.</p> <p>2.Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 3/байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх; 4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; 5/нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах; 6/аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх.</p>	<p>1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 2/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох; 3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах; 4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; 5/байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад тусалцаа үзүүлэх; 6/аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах.</p> <p>7/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих.</p> <p>8/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах; 9/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай</p>	<p>3/хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох; 4/нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох. 5/нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлэх.</p> <p>1</p>
--	--	--	---	--

	<p>2/байгаль орчныг хамгаалах талаархи саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах; 48 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд 2/нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга; 50 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл 9.Нөхөрлөл нь энэ хуулийн 31 дүгээр зүйл, тодорхой төрлийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ, тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхэлнэ.</p>	<p>7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; 8/нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах; 9/тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх; 10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах. 3.Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно. 37 дугаар зүйл.Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацаа 2.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ. 7.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.</p>	<p>тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх; 10/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах. 26 дугаар зүйл.Байгаль орчны хяналт 4/байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга. 31 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг 5/гэрээний дагуу тарьж ургуулсан ой, ургамал, үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан усны ундарга, засаж тохижуулсан газрыг сум, дүүргийн Засаг даргад хугацаанд нь хүлээлгэн өгөх; 50 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл 4.Сум дүүргийн Засаг дарга дараах баримт бичгийг үндэслэн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна: 1/баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр; 2/нөхөрлөлийн байгалийн нөөцийн менежмент явуулахыг хүссэн өргөдөл; 3/нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах менежментийн төлөвлөгөө; 4/нөхөрлөл байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээ болон иргэний үнэмлэхний хуулбар. 5.Энэ хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан бичиг баримтыг бүрдүүлсэн нөхөрлөлтэй сум, дүүргийн Засаг дарга үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно. 8.Нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр явуулах үйл ажиллагааг дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга зогсоож, гэрээг цуцална:</p>	
--	---	--	---	--

				<p>1/нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан;</p> <p>2/гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, гэрээ байгуулснаас хойш зургаан сар байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй;</p> <p>3/бүх гишүүдийн хурлаар нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гарсан;</p> <p>4/энэ хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;</p> <p>54 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг</p> <p>4.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p> <p>5. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль хамгаалагчид тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p> <p>8.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p> <p>57 дүгээр зүйл.Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх</p> <p>2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс</p>
--	--	--	--	--

				шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана.	
21	Газрын тухай хууль	<p>8 дугаар зүйл.Хилийн цэс, газар усны нэр, газар усны нэрийн болон газрын сангийн зураг</p> <p>8.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг тухайн шатны Засаг дарга, улсын хэмжээний иж бүрэн хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хадгална.</p> <p>20 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрх</p> <p>20.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>20.2.1.нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах;</p> <p>20.2.2.газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>20.2.3.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>20.2.4.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн газрын нэгдмэл сангийн тайланг жил бүр хянан нэгтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, дээд шатны Засаг дарга, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах;</p> <p>20.2.5.газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг газар эзэмшигч болон тухайн шатны Засаг даргатай</p>	<p>21 дүгээр зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>21.3.Аймгийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.3.1.сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд чиглэл өгөх;</p> <p>21.3.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна.</p>	<p>21 дүгээр зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>21.4.Сумын Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.4.1.аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд санал өгөх;</p> <p>21.4.2.аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийнхээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>21.4.3.энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах.</p> <p>52 дугаар зүйл.Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах</p> <p>52.10.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.</p> <p>53 дугаар зүйл.Хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах</p> <p>53.1.Сум, дүүргийн Засаг дарга мэргэжлийн эрх бүхий байгууллагатай хамтран хадлангийн талбайд газар зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний хэрэгжилтийг хангана.</p> <p>53.2.Сум, дүүргийн Засаг дарга хадлан авах бололцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахаар баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн хуваарилж, түүний хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>53.3.Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хориглоно.</p> <p>53.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон бэлчээрийн зохих ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болно.</p>	<p>22 дугаар зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>22.2.Баг, хорооны Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>22.2.1.газрын тухай хууль тогтоомж, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаархи нийтлэг шаардлагын биелэлтийг хангуулах;</p> <p>22.2.2.дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас газрын ашиглалт, хамгаалалтын талаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;</p> <p>22.2.3.нутаг дэвсгэртээ нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хариуцах.</p>

	<p>тохиролцсоны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх; 20.2.6.газрын төлөв байдлыг илэрхий доройтуулсан нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газрыг албадан чөлөөлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 20.2.7.газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон доод шатны Засаг даргын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах; 20.2.8.аймаг, нийслэлийн газрын албаны даргыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн газрын албаны даргыг нийслэлийн газрын албаны даргатай зөвшилцөж дүүргийн Засаг дарга тус тус томилох, чөлөөлөх; 20.2.9.газар эзэмшигч, ашиглагч нь хууль тогтоомж, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, гомдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах. 20.3.Аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны даргыг газрын харилцааны зохих мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно. 23 дугаар зүйл.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, эрх хэмжээ 23.2.11.газрын талаархи хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг тухайн шатны Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; 23.3.4.газрын тайланг зохих журмын дагуу гаргаж Засаг даргад тайлагнах; 26 дугаар зүйл.Газрын кадастр, газрын нэгдмэл сангийн тайлан 26.5.Газрын нэгдмэл сангийн сум, дүүргийн тайланг Засаг дарга тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар тасалбар болгон гаргаж, 12</p>		<p>Энэ нь газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн газарт хамаарахгүй. 53.5.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сумын Засаг дарга уг талбайг нь эзэмшүүлж болно. 54 дүгээр зүйл.Тариалангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах 54.4.Тариалангийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна. 57 дугаар зүйл.Газрын нэгдмэл санд төрийн хяналт тавих 57.3.Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө. 57.4.Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.</p>	
--	---	--	---	--

		<p>дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад; газрын нэгдмэл сангийн аймаг, нийслэлийн тайланг Засаг дарга дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргаж өгнө.</p> <p>32 дугаар зүйл.Газар эзэмших тухай хүсэлт гаргах</p> <p>32.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу гаргана.</p> <p>33 дугаар зүйл.Газар эзэмшүүлэх шийдвэр гаргах</p> <p>33.1.1.энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;</p> <p>33.1.2.энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.</p> <p>36 дугаар зүйл.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны үнэ, үйлчилгээний хураамж</p> <p>36.1.Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно.</p> <p>37 дугаар зүйл.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах</p> <p>37.1.Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн</p>			
--	--	--	--	--	--

		<p>шатны Засаг даргад гаргах бөгөөд дараахь баримт бичгүүдийг хавсаргана: 37.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба бүртгэнэ. 38 дугаар зүйл.Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 38.3.Эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай хүсэлтийг тухайн шатны Засаг дарга хүлээн авч дараахь зүйлүүдийг тодруулна: 38.3.1.энэ хуулийн 38.2-т заасан шаардлагыг хангасан эсэх; 38.3.2.шилжүүлэхийг хүссэн эрхийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх; 38.3.3.эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг эзэмших эрхтэй эсэх. 38.4.Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлснээр эрхийн гэрчилгээг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр болно. 40 дүгээр зүйл.Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох 40.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно: 40.1.1.эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн; 40.1.2.газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон; 40.1.3.шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;</p>			
--	--	--	--	--	--

		<p>40.1.4.байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, энэ хуулийн 31.4-т заасны дагуу палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгаа хийлгээгүй, зөвшөөрөл аваагүй нь тогтоогдсон;</p> <p>40.1.5.эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;</p> <p>40.1.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй.</p> <p>40.1.7.газар эзэмших эрхтэй этгээд нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17.2-д заасны дагуу холбогдох татварыг тодорхойлж тайлагнаагүй, үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан.</p> <p>40.2.Энэ хуулийн 40.1-д заасан үндэслэл тогтоогдвол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон захирамж гаргаж, энэ тухайгаа эрхийн гэрчилгээ эзэмшиж байсан буюу түүнийг барьцаалсан этгээдэд мэдэгдэнэ.</p> <p>40.3.Эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.</p> <p>40.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэрээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж улсын бүртгэлд тусгуулна.</p> <p>41 дүгээр зүйл.Газар эзэмших эрх дуусгавар болоход газрыг чөлөөлөх</p> <p>41.4.Энэ хуулийн 41.1-д заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй бол тухайн шатны Засаг дарга албадан нүүлгэх ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.</p> <p>42 дугаар зүйл.Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авах</p>			
--	--	--	--	--	--

		<p>42.3.Энэ хуулийн 42.2-т заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна.</p> <p>43 дугаар зүйл.Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авахад нөхөх олговор олгох</p> <p>43.4.Энэ хуулийн 42.3-т заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн шатны Засаг дарга уг гэрээ байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор нөхөх олговрыг уг газрыг эзэмшиж байсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.</p> <p>44 дүгээр зүйл.Газар ашиглуулах</p> <p>44.4.Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.</p> <p>44¹дүгээр зүйл.Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг ашиглуулах</p> <p>44¹.1.Сууц өмчлөгчдийн холбооны нэрийн өмнөөс тухайн холбооны гүйцэтгэх захирал орчны газрыг ашиглах тухай хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу уг асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий тухайн шатны Засаг даргад гаргана.</p> <p>46 дугаар зүйл.Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд ашиглах</p> <p>46.1.Засгийн газар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно.</p> <p>51 дүгээр зүйл.Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага</p>			
--	--	--	--	--	--

		<p>51.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 51.2-т заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа тухайн шатны Засаг даргад урьдчилан мэдэгдэж, хүн амд мэдээлэн, уг газрын заагийг тэмдэгжүүлж, сэрэмжлүүлэх байнгын дохио тэмдэгтүүд өөрийн хөрөнгөөр байрлуулна.</p> <p>52 дугаар зүйл.Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах</p> <p>52.2.Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.</p> <p>52.8.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>56 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах, хамгаалах</p> <p>56.4.Хот, тосгон бусад суурины доторх бусдын эзэмшил, ашиглалтад олгогдоогүй газрыг тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ашиглалтын зориулалт, ашиглаж эхлэх хугацаа бусад нөхцөл шаардлагуудыг бичсэн дохио, санамж тавих, хашаа, хайс татах, сахиул ажиллуулах зэргээр хамгаалалтад авна.</p> <p>57 дугаар зүйл.Газрын нэгдмэл санд төрийн хяналт тавих</p>			
--	--	---	--	--	--

	<p>57.1.Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина.</p> <p>58 дугаар зүйл.Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, түүнийг гаргах</p> <p>58.6.Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна.</p> <p>60 дугаар зүйл.Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх</p> <p>60.1.Газартай холбогдон үүссэн дараахь маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:</p> <p>60.1.1.газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны Засаг дарга;</p> <p>60.1.2.газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлын талаар газар эзэмшигч ба ашиглагчийн хооронд үүссэн маргааныг зохих шатны Засаг дарга;</p> <p>60.1.3.газрын төлөв байдал, чанар, түүнийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу зохих мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан албан тушаалтан буюу тухайн шатны Засаг дарга;</p>			
--	---	--	--	--

22	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	<p>8 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>8.1.Бүх шатны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ оршдог нийт байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах;</p> <p>8.1.2.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ мэдээлэх, сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүн, биелэлтийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу дээд шатны Засаг дарга, Засгийн газарт мэдээлэх.</p> <p>12 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн бүрэн эрх</p> <p>12.1.1.холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах талаар зохиож байгаа ажил, түүний явц, үр дүнгийн тухай Засаг дарга, өөрийн нутаг дэвсгэр дэх тухайн засаг захиргааны нэгжид харьяалагдах байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчдын мэдээллийг сонсох, илтгэл сонсголыг хэлэлцэх;</p> <p>12.1.4.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж хянан шалгах бүрэн эрхээ Засаг дарга хангалтгүй хэрэгжүүлж байна гэж үзвэл түүнийг бүрэн эрхийн нь хугацаа дуусахаас өмнө огцруулах тухай саналыг Ерөнхий сайд буюу дээд шатны Засаг даргад тавих;</p>	<p>8 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>8.2.Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх:</p> <p>8.2.1.Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлэх;</p> <p>8.2.2.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж байгаа байдлыг судлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж нэгтгэн, тэдгээрийг боловсронгуй болгох саналаа Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн мэдүүлэх;</p> <p>8.2.3.сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна.</p> <p>10 дугаар зүйл.Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, түүний нийтлэг бүрэн эрх</p> <p>10.5.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга томилно.</p>	<p>8 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>8.3.Сум, дүүргийн Засаг даргын тусгай бүрэн эрх :</p> <p>8.3.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах талаар зохиож байгаа ажил, түүний явц, үр дүнгийн тухай нутаг дэвсгэртээ оршдог байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчдын мэдээллийг сонсож, илтгэл сонсголыг хэлэлцэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах.</p>	
----	-------------------------------------	--	--	---	--

23	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль			<p>40 дүгээр зүйл.Нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагчийг томилох</p> <p>40.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.</p>	
24	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль		<p>18 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:</p> <p>18.1.1.тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;</p> <p>18.1.2.хэрэглэгчид хэрэглээний соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах;</p> <p>18.1.3.тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх.</p>		
25	Монгол улсын засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	<p>7 дугаар зүйл. Удирдлагын тогтолцоо</p> <p>7.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:</p> <p>7.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;</p> <p>7.1.2.баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал;</p> <p>7.1.3.энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан Хурлын хуралдааны чөлөө цагт тэдгээрийн Тэргүүлэгчид;</p> <p>7.1.4.аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга.</p> <p>26 дугаар зүйл. Засаг дарга, түүнийг томилох</p> <p>26.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн.</p> <p>26.2.Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож</p>	<p>30 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>30.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>30.1.1.сум, дүүргийн Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах;</p> <p>30.1.2.аймгийн Засаг дарга нэгээс илүүгүй, нийслэлийн Засаг дарга хоёроос илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;</p> <p>30.1.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх бодлого боловсруулж Хурлаар батлуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>31 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</p> <p>31.1.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>31.1.1.баг, хорооны Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах;</p> <p>31.1.2.сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;</p> <p>31.1.3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;</p> <p>31.1.4.эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох;</p>	<p>28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p> <p>28.1.Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>28.1.1.төр, засгийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>28.1.2.хадлан, тэжээл бэлтгэх, отор нүүдэл, мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ноос ноолуур авах, хашаа саравч барих, худаг ус гаргах, тариа ногоо тарих, хураах, өвөлжилтийн бэлтгэл хангах, мал тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах зэрэг цаг үеийн ажлыг хугацаанд нь гүйцэтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p>

	<p>байгаа иргэд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно.</p> <p>26.3.Энэ хуулийн 26.2-т зааснаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Монгол Улсын Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг сум, дүүргийн Засаг дарга тус тус 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд нөхөн томилогдсон Засаг даргад энэ хугацаа хамаарахгүй.</p> <p>26.4.Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй.</p> <p>26.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>26.5.1.дээд боловсролтой;</p> <p>26.5.2.төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан;</p> <p>26.5.3.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;</p> <p>26.5.4.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;</p> <p>26.5.5.ялгүй байх.</p> <p>26.6.Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>26.6.1.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;</p> <p>26.6.2.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;</p> <p>26.6.3.ялгүй байх.</p>	<p>30.1.4.Хурлын шийдвэрийн үндсэн дээр орон нутгийн өмчийн оролцоотой гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр байгуулах, тэдгээрт газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах;</p> <p>30.1.5.газрын эзэмшил тогтоох, эдэлбэр газар олгох, байгалийн баялаг, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>30.1.6.нутаг дэвсгэртээ батлан хамгаалах, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг удирдах, цэргийн анги, салбар, улсын аюулгүй байдлыг хангах болон хууль хяналтын бусад байгууллагатай харилцан ажиллах;</p> <p>30.1.7.иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх, хяналт тавих;</p> <p>30.1.8.Засаг даргын зөвлөл байгуулж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг нь батлах;</p> <p>30.1.9.сум, дүүргийн Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих;</p> <p>30.1.10.хууль тогтоомжид заасан бол нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагын удирдлагыг аймаг, нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;</p> <p>30.1.11.хууль тогтоомжид заасан бол орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагыг Хуралтай зөвшилцөн томилох, чөлөөлөх;</p> <p>30.1.12.нутаг, дэвсгэртээ тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай саналыг боловсруулж, Хуралд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>30.1.13.харьяалах нутаг дэвсгэрт нь ашигт малтмалын хайгуулын болон</p>	<p>31.1.5.албан татвар, төлбөр, хураамж хураах, зохих төсөвт шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээ авах;</p> <p>31.1.6.нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, ариун цэврийн байдалд хяналт тавьж, үйлчилгээний цагийн хуваарь тогтоох;</p> <p>31.1.7.хот, тосгоны иргэдийг цэвэр усаар хангах, хог хаягдал, бохир ус зайлуулах, цэвэрлэх, мод, бут, сөөг, жимсний мод тарьж ургуулах, тохижуулах, гудамж талбайг гэрэлтүүлэх, үер усны хамгаалалт, далан суваг барих арга хэмжээ авах, түүнчлэн харьяалах нутаг дэвсгэрт нь барилга байгууламж барих, зам, холбооны шугам өөрчлөхөд оршин суугчдын санал авч шийдвэрлэх;</p> <p>31.1.8.хууль тогтоомжид заасан бол тухайн нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын ажилтанг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;</p> <p>31.1.9.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64.4, 64.5-д заасан журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлэх;</p> <p>31.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>	<p>28.1.3.хүн амын эрүүл мэндийн байдалд ажиглалт хийж, өвчтэй хүмүүсийг эмчлүүлэх, сувилуулах, эмнэлгийн яаралтай тусламжийг цаг тухайд нь үзүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>28.1.4.хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад орон нутгийн нөөц бололцоог илрүүлж ашиглах ажлыг зохион байгуулах, энэ талаар иргэдээс гаргасан санаачилгыг дэмжих;</p> <p>28.1.5.хүн амын боловсролын түвшинг судлах, сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;</p> <p>28.1.6.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>28.1.7.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судлах;</p> <p>28.1.8.хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах;</p> <p>28.1.9.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, энэ хуулийн 29.1.6."б"-д заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p> <p>28.1.10.статистикийн мэдээллийг зохих журмын дагуу гаргах;</p> <p>28.1.11.хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэх;</p> <p>28.1.12.захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;</p> <p>28.1.13.байгалийн баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд</p>
--	--	--	---	---

	<p>26.7.Засаг даргыг өөр ажилд томилох шаардлага гарвал томилох эрх бүхий албан тушаалтан зохих шатны Хурлын Тэргүүлэгчидтэй урьдчилан зөвшилцөнө.</p> <p>26.8 Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тухайн Хурлын болон дээд шатны Засаг даргын өмнө, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн Хурлын болон Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна.</p> <p>26.9.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ажлаа тухайн Хуралд, баг, хорооны Засаг дарга иргэдэд тус тус жил бүр тайлагнана.</p>	<p>ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход тухайн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн санал өгөх;</p> <p>30.1.14.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон аргачлалын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг тус бүрээр нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тогтоож мөрдүүлэх;</p> <p>30.1.16.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;</p> <p>30.1.17.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>	<p>олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавих;</p> <p>28.1.14.гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>28.1.15.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулга явуулах, түүнчлэн эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хуулийн төсөл, төр нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>28.1.16.иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;</p> <p>28.1.17.нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагын тайланг иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>28.1.18.нутаг дэвсгэрт нь байнга буюу түр оршин суугч иргэд иргэний үндсэн ба журамт үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;</p> <p>28.1.19.нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, албан газар, байгууллага, түүнчлэн байнга буюу түр оршин суугч иргэдэд захиргааны журам, дээд шатны болон иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг, чиглэл өгч биелэлтийг нь хангуулах, тэдгээрээс дэмжлэг тусалцаа авах;</p> <p>28.1.20.иргэнийг шагнаж урамшуулах, гачигдалтай иргэнд тусламж дэмжлэг үзүүлэх тухай саналыг сум, дүүргийн Хурал, Засаг дарга тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>28.1.21.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>28.2.Баг, хорооны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.</p> <p>28.3.Баг, хорооны Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл сум, дүүргийн Засаг дарга өөрчлөх буюу хүчингүй болгоно.</p>
--	--	---	---

					<p>28.4.Баг, хорооны Засаг даргыг энэ хуулийн 32.1, 32.2-т заасан үндэслэл, журмаар ажлаас нь чөлөөлөх буюу огцруулна.</p> <p>28.5.Баг, хорооны Засаг даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг тухайн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.</p> <p>28.6.Баг, хорооны Засаг дарга тогтоосон журмаар үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p> <p>28.7.Баг, хорооны Засаг даргын цалин, ажлаа явуулахтай холбогдсон бусад зардлыг сум, дүүргийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p> <p>28.8.Баг, хорооны Засаг дарга иргэдэд урамшил, дэмжлэг тусламж үзүүлэх, ажлаа хэвийн явуулах нөхцлийг хангах зориулалт бүхий мөнгөн хөрөнгийн сантай байж болох бөгөөд зарцуулалтынх нь дүнг сум, дүүргийн Засаг дарга болон иргэдийн Нийтийн Хуралд тайлагнана.</p>
26	Хөдөлмөрийн тухай хууль	<p>15 дугаар зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх</p> <p>15.3.Сум, дүүргийн түвшинд байгуулсан хэлэлцээрийг сум, дүүргийн Засаг дарга нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 15 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлэхээр хүргэнэ.</p> <p>17 дугаар зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэд талууд хяналт тавих</p> <p>17.2.Бүх түвшинд байгуулагдсан хэлэлцээрийн биелэлтэд талууд болон тэдгээрийн төлөөлөгчид, түүнчлэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.</p> <p>115 дугаар зүйл.Хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх, шаардлага тавих, түүнд хариу өгөх</p> <p>115.1.Энэ хуулийн 12.5-д заасны дагуу хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах явцад үүссэн санал зөрүүтэй асуудлаар болон хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг биелүүлэх талаар шаардлага тавьж хөдөлмөрийн хамтын маргаан</p>			

		<p>үүсгэх эрхийг ажилтны төлөөлөгчид эдэлнэ.</p> <p>115.2.Шаардлагыг гэрээ, хэлэлцээрт оролцогч нэг тал нь нөгөө талд бичгээр өгнө.</p> <p>115.3.Шаардлагын хувийг тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.</p> <p>115.4.Шаардлага авсан тал ажлын гурван өдрийн дотор хариуг нөгөө талд бичгээр өгнө.</p> <p>139 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт</p> <p>139.1.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд дараахь этгээд хяналт тавина:</p> <p>139.1.1.улсын хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ;</p> <p>139.1.2.орон нутагт хөдөлмөрийн улсын хяналтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хяналтын алба хэрэгжүүлнэ;</p> <p>20 дугаар зүйл.Хамтын хэлэлцээрт оролцогч талууд</p> <p>20.4.3.бүсийн хэлэлцээрт тухайн бүс нутгийн аймаг, нийслэлийн Засаг дарга, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах бүс нутгийн байгууллага;</p> <p>20.4.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн хэлэлцээрт тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах тухайн нутаг дэвсгэрийн байгууллага;</p>		
27	Зөрчлийн тухай хууль	<p>15.28 дугаар зүйл.Орон нутгийн хамгаалалтын тухай хууль зөрчих</p> <p>2.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн болон ажилтныг үүрэг гүйцэтгэх боломжоор хангах, орон нутгийн хамгаалалтын сургалт, зохион байгуулалттай бусад арга хэмжээнд хамруулах үүргээ биелүүлээгүй, эсхүл аймаг, нийслэлийн Засаг даргаас тогтоосон даалгавар, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөгөөр хүлээсэн</p>		

		үүргээ гүйцэтгээгүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.		
28	Захиргааны ерөнхий хууль	<p>19 дүгээр зүйл.Төлөөлөгчийг томилох</p> <p>19.1.Захиргааны байгууллагын оршин байгаа газрын сум, дүүргийн Засаг дарга дараах оролцогчийн хувьд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалан оролцох төлөөлөгчийг томилно:</p> <p>19.1.1.оролцогч хэн болох нь тодорхойгүй бол;</p> <p>19.1.2.оролцогчийн оршин байгаа хаяг нь тодорхойгүй, байнгын оршин суугаа хаягтаа байхгүй, эсхүл удаа дараа /хоёр буюу түүнээс дээш/ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол;</p> <p>19.1.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй, төлөөлөн хүлээн авах этгээдийг нэрлээгүй бол;</p> <p>19.1.4.захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах эзэнгүй эд юмстай холбоотой үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай бол.</p> <p>74 дүгээр зүйл.Төлөвлөгөөнд сонсох ажиллагаа явуулах</p> <p>74.3.Төлөвлөгөөг танилцуулснаас хойш 30 хоногийн дотор чиг үүргийн дагуу санал өгөх үүрэгтэй захиргааны байгууллага болон төлөвлөлт хийгдэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга тайлбар, саналаа гаргаж өгөх үүрэгтэй.</p>		<p>64 дүгээр зүйл.Захиргааны хэм хэмжээний актыг баталж, хүргүүлэх</p> <p>64.5.Сум, дүүргийн Засаг дарга гаргасан захиргааны хэм хэмжээний актаа ажлын 10 өдөрт багтаан дээд шатны Засаг даргаар дамжуулан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p>
29	Монгол улсын Үндсэн хууль	<p>Жардугаар зүйл.</p> <p>1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.</p> <p>2.Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.</p> <p>3.Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2</p>		

		<p>дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.</p> <p>Жаран нэгдүгээр зүйл.</p> <p>1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.</p> <p>2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.</p> <p>3. Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.</p> <p>4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.</p> <p>Жаран хоёрдугаар зүйл.</p> <p>1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.</p> <p>2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.</p> <p>3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.</p>			
--	--	---	--	--	--

		<p>Жаран гуравдугаар зүйл.</p> <p>1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.</p> <p>2.Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.</p> <p>3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.</p>			
30	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	<p>7¹ дүгээр зүйл.Худалдан авах ажиллагаан дахь олон нийтийн оролцоо</p> <p>7¹.1.Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан төвлөрүүлэн захирагч нь холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрснөөр харьяалагдах байгууллагын төсвийн хүрээнд худалдан авах нэг төрлийн бараа, ажил, үйлчилгээг нэгтгэн, нийлүүлэгч болон гүйцэтгэгчийг нь сонгон шалгаруулж болно.</p> <p>45 дугаар зүйл.Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p> <p>45.1.Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.</p> <p>45.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна:</p> <p>45.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг,</p>	<p>53 дугаар зүйл. Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг</p> <p>53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.</p> <p>53.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлнө.</p>		

		<p>байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд;</p> <p>45.2.2.аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутаг худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд.</p> <p>45.3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар</p> <p>45.6.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно.</p> <p>47 дугаар зүйл.Үнэлгээний хороо</p> <p>47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.</p>			
--	--	--	--	--	--

